



IX/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 13




Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2021 оны 9 дүгээр сард өмнөх сараас 4.6 хувиар өссөн байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 9 дүгээр сард 157.2 болж, өмнөх оны мөн үеэс 18.2 хувь, өмнөх оны эцсээс 8.6 хувь, өмнөх сараас 4.6 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 9 дүгээр сард 164.7 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 39.1 хувь, өмнөх оны эцсээс 22.6 хувь, өмнөх сараас 2.8 хувиар тус тус өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 39.1 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 43.6 хувиар (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс, түүхий нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 9 дүгээр сард 104.8 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 17.7 хувь, өмнөх оны эцсээс 12.9 хувиар тус тус өссөн байна. Харин өмнөх сараас 1.8 хувиар буурсан байна. Импортын үнийн индекс өмнөх сараас 1.8 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 1.7 хувиар (нефть), машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгслийн бүлгийн үнэ 6.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС¹ (2015=100), хувь



¹ Туршилт тооцоо

Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.



Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

Эх үүсвэр:

Гаалийн Ерөнхий Газар

Ангилал:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2021 оны 12 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Мөнхтуул
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212